ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР
ЗӨВЛӨЛ

2022.02.18 № 01

танай ____ -ны № ____

БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Т.ЦЭВЭЛМААД

П.Отгончимэгт санал, дүгнэлт
гаргах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 05/4408 тоот албан бичиг, Баянжаргалан сумын Засаг дарга Т.Цэвэлмаагийн 2022 оны 1/72 тоот албан бичгийг тус тус үндэслэн П.Отгончимэгт дараах санал дүгнэлтийг гаргаж байна.

Нэг. Баянжаргалан сумын Соёлын төвийн эрхлэгч Б.Батчимэгийг жирэмсэн, амаржсаны амралттай байх хугацаанд түүний албан үүргийг түр орлон гүйцэтгэх хүн байхгүй учир тус байгууллагын номын санч П.Отгончимэгээр түр орлон гүйцэтгүүлэхээр Баянжаргалан сумын Засаг дарга Т.Цэвэлмаагаас ирүүлсэн хүсэлтийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 2 дугаар хуралдаанаар хэлэлцээд тус ажлын байрны түр орлон гүйцэтгэгчээр Албан тушаалын шаардлага хангах хүн тухайн байгууллагад байхгүй гэх нөхцөл байдал, мөн Авлигатай тэмцэх газрын 2022 оны "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай" 05/4408 дугаар албан бичигт П.Отгончимэгт тухайн албан тушаал дээр ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно гэх дүгнэлтийг тус тус харгалзан Баянжаргалан сумын Соёлын төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн албан тушаалд Пүрэвжав овогтой Отгончимэгийг албан ажлын зайлшгүй шаардлагаар Б.Батчимэгийн жирэмсэн амаржсаны хугацаа дуусах хүртэл хугацаанд ажиллуулахыг дэмжлээ.

Хоёр. П.Отгончимэгийг хөдөлмөрийн хугацаатай гэрээгээр өөрийн үндсэн ажлын зэрэгцээгээр тухайн албан тушаалд түр томилох, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Т.Цэвэлмаад зөвлөж байна.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
[illegible]

2022.03.31-ны 05/4408

ДУНДГОВЬ АЙМГИЙН
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Т.ЦЭВЭЛМАА ТАНАА

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай

Дундговь аймгийн Баянжаргалан сумын Соёлын төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Пүрэвжавын Отгончимэгийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч П.Отгончимэг нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын Соёлын төвийн даргын албан тушаалын тодорхойлолтод заасан "Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх" шаардлагыг хангаагүй байна.

Мөн П.Отгончимэг нь Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам"-д заасны дагуу сонгон шалгаруулалтад хамрагдаагүй байх тул нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийг томилохдоо Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэх нь зүйтэй.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР Т.ЭНХБОЛД